

ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХҮЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ

/1921 оны үеийн сэтгэлгээний ерөнхий тойм/

DEVELOPMENT OF CRIME INVESTIGATION THOUGHTS

/General overview of thoughts withing the period 1921/



Н. МАНЛАЙБААТАР ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол тактикийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн магистр, докторант, цагдаагийн ахмад

MANLAIBAATAR N. Dean of the Faculty of Theory and Tactics of the Investigation, Police institute, Law Enforcement University, Law of master, Police captian

Товч агуулга: Энэхүү илтгэл нь гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хөгжлийн тодорхой үеийг авч үзэж байгаараа онцлог бөгөөд 1921 оны үеийн зарим нөхцөл байдлыг хөндөж байгаа юм. Тухайн үед гэмт хэрэг мөрдөхүйд нөлөөлж байсан бүхий л үзэгдлийг системийн хэмжээнд нь бус хэсэгчлэн авч үзлээ.

Abstract: Peculiarity of this research is in its consideration of the certain stage of the development of crime investigation thoughts. In this case all the phenomenon influencing the investigation of crimes are not addressed under the entire system, but it was considered partly.

Түлхүүр үг:

- Гэмт хэрэг мөрдөхүй – CRIME INVESTIGATION

Гэмт хэрэг мөрдөхүй нь улс орны дотоод аюулгүй байдлыг хангах баталгааг бүрдүүлж байдаг төрийн онцгой үүрэг, эрхийн нэгдэл бөгөөд гагцхүү ямар сэтгэлгээ, уламжлал, үзэл номлол тухайн цаг үедээ нөлөөлж байсныг илрүүлэн судлахад нэлээд хүч, чармайлт шаардсан ажил болох нь илэрхий билээ. Энэхүү илтгэл нь үндсэндээ гэмт хэрэг мөрдөж ирсэн 20-р зууны дийлэнх хувийг хамарч байгаагаараа нэгэн онцлогтой.

1921 онд ардын хувьсгал ялснаас хойш Монгол орны аж амьдрал, уламжлалт сэтгэлгээнд их эргэлт гарсан он жилүүд байсныг бид өдгөө тэмдэглэсээр ирлээ. Дэлхий нийтээрээ өнгөрсөн зууны эхэнд түүхэн сонголт хийсэн он жилүүд эхлэж үндсэндээ капиталист болон социализмын замаар их гүрнүүд замнаж буй үед манай улс жижиг буурай хэдий ч сонголт хийх түүхэн цаг байж дэлхий нийтийн интеграцчлалд эргэлт буцалтгүй орсон билээ.

Хэдийгээр хувьсгалын жилүүдэд тус улсын сэхээтэн, эрдэмтэд мөн л аль замналаар замнахаас шалтгаалж улсын хувь заяа шийдэгдэнэ хэмээн мэтгэлцэж байсан хэдий ч геополитикийн хатуухан

тоглоомонд ямар ч сонголтгүйгээр Оросыг дагаж социализм байгуулах үйл хэрэгт улс даяараа нэгдэн орсон юм.

Энэ нь хэдийгээр гарцаагүй сонголт мэт хэдий ч тусгаар улс байх бүхий л нөхцөл гагцхүү хойд хөршөөс хамааралтай байсан жилүүдэд жижиг гүрний нөлөө үнэн хэрэгтээ их байгаагүй билээ. Үүний улмаас үйлдвэржиж буй Орос орноос барууны хэв шинж бүхий соёлын урсгал эрчимтэйгээр түрэн орж ирсэн билээ. Марксизм, Ленинизмын гэх тодотгол бүхий онол, сэтгэлгээ, философи нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, шашин, хүмүүнлэгийн бүхий л салбараар нэвтэрч⁶ эхэлсэн билээ.

Ийнхүү улс төр, эдийн засаг, соёлын шинэлэг интеграци нэвтрүүлэх гол хөрс нь Монголчуудын дасан зохицох хийгээд Манжийн дарлалд дарлагдсан олон жилийн сэтгэлгээ, улс төр, эрх чөлөөний хүлээтэй байдлаас гарах гэсэн их хүсэл тэмүүлэлийн

⁶ Манай улс олон жилийн турш шашны нөлөөнд оршиж сэтгэлгээний хувьд ихээхэн хоцорч танин мэдэх бүхий л зүйлээ буран шашнаас хамаатай мэтээр үзэж байснаа огцом эргэлт хийж энэхүү онол, сэтгэлгээгээр замнаж эхлэсэн түүхтэй. К.Маркс нарын үзэж байснаар “Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн” гэсэн үзэл сэтгэлгээг хүлээн авахад амаргүй байсан нь мэдээж. Маш хүнд байсан боловч өөрчлөгдөж эхлэсэн билээ.

нийлбэр цогц байсан билээ.

Бид энэ цаг үеэс хойш улс орны дотоодод гарсан өөрчлөлт, шинэчлэлтийн түүхээ дунд гэмт хэргийн тухай үзэл сургаалийн тухайд болон гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний өөрчлөлтүүдийн талаар дараах ангилалыг хийж байгаа юм. Үүнд:

1. Гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний уламжлалт хэв загвараас өрнийн үзэл санаанд шилжилт хийж эхлэсэн үе /1921-1931 он хүртэл/
2. Гэмт хэрэг мөрдөхүй нь гүрнээс хамааралтай тэдний үзэл санаанд биширч даган дуурайсан /дарлалд нь байсан/ үе /1931-1942 он/
3. Гэмт хэрэг мөрдөхүйд социалист хэв шинж бүхий үзэл санаа төлөвшиж намын дарангуйлалд шилжсэн сэтгэлгээний үе /1942-1962 он/
4. Гэмт хэрэг мөрдөхүйд коммунизмыг байгуулах ажлыг эрчимжүүлэх сэтгэлгээ нөлөөлсөн үе⁷ /1962-1989/ хэмээн ангилж болох юм. Нийгэм түүхийн үзэгдлийн эргэх холбоо, харилцан хамаарал, соёл иргэншил, үнэт зүйл, ард түмний аж төрөх арга барил, уламжлал, ёс зүй, хүний эрх, улс төрийн байгууламж, эдийн засаг, нутаг дэвсгэр гээд бүхий л талаас нь авч үзэж байж ангилал хийдэг болохыг энд анзаарахгүйгээр таамаг төдийгөөр хийсэн ангилал бус юм.

Энэхүү ангилалыг бичихдээ бид нэлээд хэдэн шалгуур тавьсан билээ. Үүнд: Геополитикийн нөхцөл байдал, хүн амын сэтгэлгээний төлөв, аж амьдрал, гэнэн итгэмтгий ард иргэд, улс төр, эдийн засгийн харилцаа, соёл, шинжлэх ухаан танин мэдэхүйн үзэл санаа гээд харилцан шүтэлцээнд авч үзэхийг зорсон билээ. Нэгэнт 1921 онд ардын хувьсгал ялж Ардын засгийг байгуулсан нь түүхэн үйл явдал хэдий ч Монголчуудын сэтгэлгээ хоцрогдсон байсныг далимдуулан том гүрнүүдээс газар нутаг, баялагт нь шунах үйл явц даамжрах төлөвтэй болж тухайн үеийн сэхээтнүүдийг устгахын тулд төрөл бүрийн гэмт хэрэгт холбогдуулан шалгаж цаазлах явдал гарч эхэлснийг ард нь хэн зохион байгуулж байгааг жирийн ард, иргэд ойлгоогүй билээ.

Өрнийн соёлтой танилцаж буй монголчууд тэднийг бишрэх нөгөөтэйгүүр суралцах зүйл байсан нь мэдээж их байсан хэдий ч өөр хооронд нь тэмцэлдүүлж хагалах, хядлага явуулах эхлэл болсныг тухай үеийн улс төрийн зүтгэлтнүүд л мэдэж байснаас хэтрээгүй болов уу.

Олон зуун жилийн туршид шашин номын мөрөөр замнасан Монголчуудын сэтгэлгээ үнэхээр өрнийн сэтгэлгээний нөлөөг эхэн үедээ хүлээж авахад хүнд тусаж байсан нь сонигч, аливаа өөрчлөлтийг хурдан хүлээн авч дасан зохицох чадвар нь богино хугацаанд уламжлалт сэтгэлгээгээ өөрчлөх үндэс суурь нь болж

чадсан юм.

Гэмт хэрэг мөрдөхүйд хүчтэй нөлөөлж байсан хуучин эрүү шүүлт⁸-ээс ангид байх үндсэн үзэл сэтгэлгээг Оросын сэхээтнүүд болон үндэсний сэхээтнүүдээс номлож эхлэсэн нь томоохон түлхэц болж өрнийн гэмт хэрэг мөрдөх онцлог бүхий соёлын үндсэн нэвтрэлт болсон байна. Энэ талаар шинжлэх ухааны доктор С.Жанцан агсан өгүүлэхдээ “Монгол оронд өрнөсөн 1921 оны Ардын хувьсгал нь жинхэнэ ард түмний хүсэл зоргийг илэрхийлсэн цоо шинэ хувьсгалт Эрүүгийн эрх зүй үүсч хөгжих эхлэлийг тавьсан”⁹ хэмээн авч үзсэн нь нөгөөтэйгүүр “Гэмт хэрэг мөрдөх сэтгэлгээний мөн л шинэ эхлэлийг тавьсан /эрүүгийн процессын эрх зүйн шинэчлэл/” гэж үзэж болохоор байна.

Ардын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын санаачлагаар 1921 оны 03 дугаар сарын 03-нд гаргасан захирах захирагдах журмын тогтоолд “... ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёсон болбоос захирах захирагдахын ёсон ба эрүү шүүлт яллах залхаахыг бүрнээ устгасан гагцхүү дээдэс нь доордыг учиргүйгээр эзэрхэж дарлах ба доордос нь мөн түүний эрх сүрт дарагдаж өгүүлэх газаргүй болон зүдэж дарлагдах муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон нь болой”¹⁰ гэсэн нь энэ цаг үеийн шинэчлэлт өөрчлөлтийн агуулгыг илтгэх нөгөөтэйгүүр аливаа гэмт хэргийг хуучин шашинжсан субъектив хандлагаас ангижруулан шинжлэх ухааны объектив мэдлэгт тулгуурласан гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний шинэ эргэлт хийсэн үе хэмээн үзэж байгаа билээ. Гэвч гэмт хэрэг мөрдөхүйд эрүү шүүлт¹¹-т зарим талаар хэрэглэж байсныг судлаачид тогтоосон.

Гэвч аливаа шинэчлэлт өөрчлөлт нь нэг талаас хуучинсаг ахмад үе нөгөө талаас өөрчлөлт хийх гэсэн залуу эрх хүчтэй үеүүдийн хооронд диалектик зөрчил гарцаагүй бий болохын зэрэгцээ саад тотгор хийх, хорлон сүйтгэх, аль алиныхаа сул талыг илчлэх, өөр өөрсдийн давуу талаа хэт дөвийлгөх, ард түмнийг дагуулах гэсэн туйлын хүсэл эрмэлзлэлийг илэрхийлж байдаг. Энэхүү сэтгэлгээний үүднээс авч үзвэл гэмт хэрэг мөрдөхүйд энэ үе нь нөлөөлж байсан гэдгийг анхаарах хэрэгтэй.

Монголчууд гэмт хэрэг мөрдөхүйн уламжлалт эрүү шүүлтийг халах явдал нь тухайн цаг үеийнхээ

⁸ “Эрүү шүүлт” бол хуучин бүдүүлэг нийгмийн үлдэгдэл гэж үзэх үзэл сэтгэлгээг тухайн үед хүчтэй дэлгэрүүлж байсан баримт байдгийг бид мэднэ. Тийм ч учраас илүү нуршихгүйгээр товч тэмдэглэсэн юм.

⁹ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. I. УБ., 2009 он. 69 дэх тал.

¹⁰ Монголын үнэн сонин. 1921.03.25 №5. Дам иш татав.

¹¹ 1932 онд сараалж эрүүг хэрэглэж байсан баримт байна. Гэтэл 1921 онд есөн эрүүг устгасан хэмээж байсан хэдий ч 1930-аа оныг хүртэл зарим тохиолдолд хэрэглэж байжээ. Энэ тухай ХЗҮХ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. /1921-2009/ УБ., 2012 он. 17 дах талд дэлгэрэнгүй үзнэ үү.

⁷ Гэхдээ энэхүү ангилал нь судлаачийн байр суурь тул алдаа хийгээд ташаарсан байх магадтай хэмээн үзэж залруулах зүйл байвал нэн таатай хүлээн авна.

хоцрогдлоос хурдан ангижрахыг хүссэн тэмүүлэл гэж ойлгож болно. Нэгэнт цаг үеэ өнгөрөөсөн сэтгэлгээний хэв шинж шинэ цагийн бодлого, дэлхий нийтийн жишиг хандлагатай тохирч өгөхгүй байгаа тохиолдолд хүчээр асуудлыг шийдвэрлэх оролдлого ямагт гарсаар ирсний жишээ бол энэхүү жигтэй хачин цаг үе байсан билээ.

Нэгэнт Монголчууд тусгаар байх эсэх асуудал хурцаар тавигдаж дэлхийн хүчирхэг гүрэн¹² нөлөөллийн бүсээ тогтоох оролдлого гарч байсан цаг үеийн томоохон бодлоготой уялдана. Энэ утгаараа тусгаар улсын бодлого хэрэгжүүлэх түүхэн цаг үед улс төрийн, үндэсний аюулгүй байдлын эсрэг чиглэсэн гэмт үйлдлүүд гарах таатай хөрс нь бүрдснийг нөгөө талаас илтгэж байсан юм. Тиймээс гэмт хэрэг мөрдөхүйд тус улсын эсрэг аливаа гэмт үйлдлийг таслан зогсоох, мөрдөн шалгах онцгой мэдлэгтэй чадвартай хүмүүсийг шаардаж байсан нь туйлын тодорхой болж байна.

Үүний тулд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал өрнөснөөр нэгэнт шинэ үе нээгдэж тухайн үеийн засгийн газраас гарч байсан эрүүгийн байцаан шийтгэх хэм хэмжээний агуулга нь:

1. Манж болон хаант улсын эрүүгийн байцаан шийтгэх хэм хэмжээг нэн даруй хүчингүй болгох,
2. Шинэ төрийн эрүүгийн хууль цааз, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үндсэн бодлого, зарчмыг тогтоох, ард түмэнд түүнийг ойлгуулах,
3. Хуучин цагийн шүүх тогтолцоог халах, шинэ тогтолцоо бүрдүүлэх бэлтгэлийг хангах зорилгыг тавьж байсан¹³ нь сэтгэлгээний шинэ тогтолцоог бүрдүүлэх гэсэн үндсэн чиглэл байжээ. Энэ үеийн гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний эрх зүйн үндсэн эх сурвалж нь 1. Ардын засгийн газраас гаргасан хуульчилсан актууд, 2. Шүүх яамнаас гаргасан актууд, 3. Улс төрд онц ноцтой хэргийг таслуулахаар Засгийн газраас байгуулсан комиссын тогтоол зэрэг байсан нь анхаарал татаж байна. Энэ талаар илүү дэлгэрэнгүй судлах баримт бичгүүд болон бусад үйл явдлуудтай харьцуулан харж үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг ажлыг цаашид хийнэ.

Энэ үеэс ангийн тэмцлийн үзэл санаа газар авч байсан нь анхаарах асуудал гэж үзэж байгаа билээ. Ямар ангид хамаарч байгаагаас шалтгаалж гэмт хэрэг мөрдөн шалгаж байгаа хүмүүсийн хандлага, сэтгэлгээ өөр өөр байсныг түүхийн тодорхой цаг үе илтгэж байна. Энэ нь цаад мөн чанараараа Ардын

Засгийн газар хууль тогтоох үйл ажиллагаандаа Зөвлөлт Орос Улсын хууль тогтоомжийн туршлагыг харгалзан үзэж эхэлсэн¹⁴-тэй хамаатай байж болох юм. Угаасаа Оросын соёлыг нэвтрүүлснээр тэднийг даган дуурайх явдал нийгмийн байгуулалын бүхий л салбараар нэвтэрч байсан нь энэхүү жишээ юм.

Энэ үеийн гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний нийтлэг хандлага нь дараах байдлаар илэрч байгаа юм.

1. Манжийн нөлөөнд 200 жил байсан учраас гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээнд дурьдан буй цаг үед ахиц гарсан хэдий ч хуучин харгис арга байсаар байжээ.
2. Оросын нөлөөг хүлээн зөвшөөрөхийн хамт тэдний соёл бүхий л талаар нэвтрэх үндсэн нөхцөл бүрдэж улмаар уламжлалт сэтгэлгээ хандлагыг өөрчилж эхэлсэн.
3. Тусгаар улс байх бүхий л нөхцлөө хангах үүднээс улс төрийн гэмт хэргийн онцгойлон шалгаж шийтгэх явдал түгээмэл байсан.
4. Мэргэжлийн хүмүүсээр дутмаг гэмт хэрэг мөрдөхүй нь уламжлалт хэв шинжээ хадгалсаар байсан нь эрүү шүүлт хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн.
5. Гэмт хэрэг мөрдөхүйд үндсэний мөрдөн шалгах эрх бүхий хүмүүс цөөн байсан нь гадаадын / Зөвлөлт Орос Улс/ зааварлагчийн сэтгэлгээ нөлөөлөх үндэс болсон.
6. Шашинжсан Монголчуудын хувь үнэт зүйл нь шашны номлол хийгээд бурхан байсан тул шашны нөлөө мөн гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээнд нөлөөлж байсан гэх зэргээр энэхүү цаг үеийн гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний ерөнхий тоймд дүгнэлт хийж болох юм. Ер нь гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний шинэ эргэлт хэдийгээр эхлэсэн гэж үзэх үндэслэлтэй хэдий ч шууд эхлээгүй нь ойлгомжтой. Цаг хугацааны явц, өөрчлөлтөд дасан зохицох, шинэлэг бодлого, үзэл санаа түгэн дэлгэрч ард түмэнд хүлээн зөвшөөрөгдөх хүртлээ тодорхой орон зай, цаг хугацааг туулдаг нь зүй тогтол юм. Энэхүү агуулгаараа Монголчуудын сэтгэлгээнд хэдэн зуун жилийн туршид шашны үзэл сэтгэлгээ оршиж, ахуй хийгээд ертөнцийг танин мэдэх эх нь бурхан хэмээн ойлгож байсан нь тийм ч амар арилахгүй нь ойлгомжтой билээ.

Иймээс идеалист үзэл сэтгэлгээнээс материализмд шилжих процесс диалектик зөрчилтэй байна. Ийм ч учраас дээрх нийтлэг дүгнэлтэнд хүрсэн. Энэхүү процесс нь сэтгэлгээний томоохон шилжилт, байсан бөгөөд нийтлэгээрээ Монголын ард түмний, явцуу утгаараа буюу хэсэгчилээд гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний шинэ эргэлт байсан билээ.

Цаашид гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хөгжлийг түүхийн тухайн цаг үеийн онцлог байдалтай нь уялдуулан авч үзнэ.

¹² АНУ, Их Британи, Хятад, Япон, Франц, Итали, Белги, Холланд, Португали зэрэг – улсууд хамаарч байсан билээ. 1922 оны 2 дугаар сард эдгээр улсууд Вашингтонд далайн асуудлаар бага хурла хийсэн. Энэ нь манай улсын хувь хамаагүй мэт боловч хэрэг дээрээ Хятад улсын бодлого Ази-номхон далайн хувьд байр сууриа бэхжүүлэх түүхэн боломжоо нээсэн үе байсан билээ.

¹³ ХЗҮХ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. /1921-2009/ УБ., 2012 он. 26 дах тал.

¹⁴ ХЗҮХ. Дурьдсан бүтээл. УБ., 2012 он. 27 дах тал.